



ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2024

Нэмэлт, Өөрчлөлт

Он,сар, өдөр	Зүйл, заалт	Өөрчлөлт	Хувилбар
2025.08.08	5.4	Крипто үйлчилгээний хураамж өөрчлөгдөв.	1.1

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

Нэг талаас: Олон улсын зах зээлийн форекс арилжааны данс нээх үйлчилгээ үзүүлэгч “MOT Форекс” ХХК болон www.motforex.com /цаашид “Үйлчилгээ үзүүлэгч” гэх/,

Нөгөө талаас: Олон улсын зах зээлийн форекс арилжаанд оролцох хүсэлтэй, энэхүү гэрээний нөхцөлтэй танилцсан, хүлээн зөвшөөрсөн иргэн /цаашид “Хэрэглэгч” гэх/, /хамтад нь “Талууд” гэх/ нар нь Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох зүйл заалтыг үндэслэн энэхүү “Хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ” /цаашид “Гэрээ” гэх/-ийг дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээний зорилт нь олон улсын зах зээлийн форекс арилжаанд оролцох хүсэлтэй иргэн таны бүртгэлийг үүсгэх, хувийн мэдээллээ баталгаажуулах, арилжааны жинхэнэ данс болон демо данс нээх, өөрийн дансны гүйлгээг удирдах, арилжааны платформд нэвтрэх данс үүсгэх үйлчилгээ /цаашид “Үйлчилгээ” гэх/-ийг үзүүлэх, хэрэглэгч үйлчилгээний хураамж төлөх зэрэг талуудын хооронд үүсэх эрх зүйн харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү гэрээ нь Монгол Улсын Иргэний хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
- 1.3. Үйлчилгээ үзүүлэгч нь олон улсын зах зээлийн форекс арилжааны гадаад валют, үнэт металл, хувьцаа, виртуал хөрөнгө зэрэг хослол бүхий бүтээгдэхүүнийг худалдан борлуулдаггүй, арилжааг зохион байгуулдаггүй бөгөөд зөвхөн энэхүү гэрээний 1.1-т заасан үйлчилгээг авах боломжтой цахим үйлчилгээний <https://www.motforex.com> платформоор хангана.
- 1.4. Энэхүү гэрээгээр зохицуулаагүй талуудын хооронд үүсэх бусад харилцааг гэрээний Хавсралт 1-т заасан “Үйлчилгээний нөхцөл”-өөр зохицуулна.

ХОЁР.ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Энэхүү гэрээг хэрэглэгчийн бүртгэл үүсгэсэн өдөр байгуулж, талуудын аль нэг нь гэрээ цуцлах хүсэлт гаргасан өдрийг хүртэлх хугацаанд байгуулсан болно.
- 2.2. Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээ болон үйлчилгээний нөхцөлийг үндэслэн нэг талын санаачилгаар гэрээг цуцлах эрхтэй.
- 2.3. Хэрэглэгч гэрээ цуцлах хүсэлтийг албан ёсны цахим шуудангаар өргөдөл илгээж, баталгаажуулна.

ГУРАВ.ХЭРЭГЛЭГЧИЙН ҮҮРЭГ, ЭРХ

- 3.1. Хэрэглэгч нь энэхүү гэрээний хүрээнд дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 3.1.1 Хэрэглэгч нь энэхүү Гэрээ болон гэрээний Хавсралт 1-т заасан “Үйлчилгээний нөхцөл”-ийг хүлээн зөвшөөрснөөр <https://www.motforex.com>-д бүртгэл үүсгэх;
 - 3.1.2 Хэрэглэгч өөрийн арилжааны дансны гүйлгээг удирдах, орлого, зарлагын болон бусад тулгамдаж буй асуудлаар Үйлчилгээ үзүүлэгчээс мэдээлэл авах, санал гомдол, хүсэлт гаргах, шийдвэрлүүлэх;
 - 3.1.3 Үйлчилгээ үзүүлэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;
 - 3.1.4 Хэрэглэгч нь арилжаанд оролцох данс нээх үйлчилгээ үзүүлдэг компанийг чөлөөтэй сонгох, өөрийн бүртгэл болон арилжааны дансыг хаах хүсэлт гаргах эрхтэй.
- 3.2. Хэрэглэгч нь энэхүү гэрээний хүрээнд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 3.2.1 Хэрэглэгч нь үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлж буй олон улсын зах зээлийн форекс арилжааны данс нээх үйлчилгээний талаар хангалттай мэдээлэлтэй байх ба хэрэв үйлчилгээний талаар эргэлзээ байвал үйлчилгээний ажилтнаас лавласан байх;
 - 3.2.2 Хэрэглэгч нь Үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчийн үйлчилгээний албаны ажилтантай зөв зохистой харилцах, харилцан хүндэтгэх;

- 3.2.3 Хэрэглэгч арилжаанд оролцохдоо үүсч болзошгүй санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мөнгөний менежментийн зарчмыг баримтлан амьдралын нэн чухал хэрэгцээтэй зүйлсийг барьцаалан эсхүл зээлийн хөрөнгөөр арилжаанд оролцохгүй байх;
- 3.2.4 Хэрэглэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн системийн доголдол болон энэхүү гэрээний 10 дугаар зүйлийн 10.1-т заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийг ашиглан үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн тохиолдолд үнэнч шударгаар мэдэгдэх, учирсан хохирлыг төлж барагдуулах;
- 3.2.5 Хэрэглэгч үйлчилгээ үзүүлэгчээс шаардсан баримт бичгийг үнэн зөв, алдаагүй, бүрэн зөв илгээх ба хувийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг ажлын 5 хоногийн дотор мэдэгдэх;
- 3.2.6 Хэрэглэгч арилжаанд оролцохдоо зөвхөн өөрийн нэр дээрх арилжааны банкны дансаар гүйлгээ хийж, зөвхөн өөрийн бүртгэлээр арилжаанд оролцох ба хууран мэхлэх, залилах үйлдэл гаргахгүй байх;
- 3.2.7 Хэрэглэгч Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний хураамжийг арилжааны данснаас суутган авах зөвшөөрлийг нэмэлт мэдэгдэлгүйгээр олгох;
- 3.2.8 Хэрэглэгч өөрийн арилжааны алдагдлын үр нөлөөг бүрэн хариуцах, ашиг орлогоосоо хувь хүний орлогын албан татварыг төлөх;
- 3.2.9 Хэрэглэгч өөрийн бүртгэл, арилжааны дансны нэвтрэх нэр, нууц үг, цахим шуудангийн хаяг зэрэг <https://www.motforex.com>-д нэвтрэх боломжтой бүхий л хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, бусдад задруулах, илгээх, сэжигтэй линк, веб сайтад бүртгүүлэх, нэвтрэх зэрэг бусад бүх төрлийн аюулгүй байдалтай холбоотой үйлдлийг хийхгүй байх;
- 3.2.10 Хэрэглэгч өөрийн бүртгэлд аливаа гуравдагч этгээд зөвшөөрөлгүйгээр нэвтрэх, таны нууц үгийг ашиглаж байгаа үйлдлийг олж илрүүлвэл нэн даруй манай хэрэглэгчийн үйлчилгээний албаны 7222-2200 дугаарт холбогдох эсхүл support@motforex.com цахим шуудангийн хаягаар яаралтай мэдэгдэх үүрэгтэй.

ДӨРӨВ.ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээний хүрээнд дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 4.1.1 Үйлчилгээ үзүүлэгч нь үйл ажиллагаа эрхлэх зах зээлээ сонгох, зарим улс орны иргэдэд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах /ФАТФ-ын саарал жагсаалт болон хар жагсаалтад багтсан/, арилжааны дансыг түр хязгаарлах, бүрэн хориглох, нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх, компанийн хар жагсаалтанд оруулах, ашгийг хүчингүйд тооцох, гэрээ цуцлах зэрэг хязгаарлалтын арга хэмжээг авах;
 - 4.1.2 Хэрэглэгч энэхүү Гэрээ болон Үйлчилгээний нөхцөлд заасан шаардлага хангаагүй хэрэглэгчид бүртгэл үүсгэх, арилжааны данс нээх үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;
 - 4.1.3 Энэхүү Гэрээ болон Үйлчилгээний нөхцөл, хөнгөлөлт, урамшууллын нөхцөлийг бие даан шийдвэрлэх;
 - 4.1.4 Хэрэглэгчээс ирүүлсэн баримт бичиг, хувийн мэдээллийг хянах, шалгах, тодруулах, дахин нэмэлт баримт шаардах;
 - 4.1.5 Хэрэглэгчийн зүй бус харилцаатай холбогдуулан шаардлагатай тохиолдолд хязгаарлалтын арга хэмжээ авч, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;
 - 4.1.6 Хэрэглэгчийн орлогын эх үүсвэрийг тодруулах, баталгаажуулах нэмэлт баримт бичиг шаардах, эрх бүхий байгууллагад мэдэгдэх, шалгуулах;
 - 4.1.7 Хэрэглэгчийн арилжааны түүхийг хянах, шалгах, зөрчилтэй эсхүл сэжигтэй тохиолдолд хэрэглэгчийн арилжааны дансыг хаах, орлого, зарлагын гүйлгээг хаах, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;
 - 4.1.8 Хэрэглэгчийн бүртгэлтэй утасны дугаар болон цахим шуудангаар үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний нөхцөл, хөнгөлөлт, урамшууллын мэдээллийг илгээх зэрэг шаардлагатай тохиолдолд хэрэглэгчийн мэдээллийг ашиглах;
 - 4.1.9 Хэрэглэгч энэхүү гэрээний 6.1 дүгээр зүйлд заасныг зөрчсөн тохиолдолд үзүүлж байгаа үйлчилгээг нэн даруй зогсоох, гэрээг цуцлах, захиалгын хүсэлтийг хаах,

дансыг хязгаарлах, хориглох, нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх, зарлага хийх эрхийг хаах, эрх бүхий байгууллагад зөрчлийг мэдээллэх зэрэг арга хэмжээг авах эрхтэй.

- 4.2 Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээний хүрээнд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 4.2.1 Үйлчилгээ үзүүлэгчийн <https://www.motforex.com>-ийн үйл ажиллагаа хэвийн тасралтгүй байх нөхцлийг бүрдүүлэх зорилготой ажиллах;
 - 4.2.2 Хэрэглэгчээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдол зэргийг ажлын 5 хоногт шийдвэрлэх;
 - 4.2.3 Энэхүү гэрээ болон үйлчилгээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд албан ёсны сувгаар дамжуулан хэрэглэгчид мэдэгдэл хүргэх үүрэгтэй.

ТАВ.ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ

- 5.1 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчид дараах үйлчилгээний хураамжийг ногдуулна. Үүнд:

Дансны төрөл	MT5 Про	MT5 Стандарт	cTrader Про	cTrader Стандарт
Хослол шимтгэл /1 лот тутамд/	\$ 3.50 per side	\$0.00	\$ 3.50 per side	\$0.00

- 5.2 Энэхүү гэрээний 5.1-т заасан үйлчилгээний хураамжийг Хэрэглэгчийн үүсгэсэн дансны төрлөөс хамааран ялгаатай ногдуулна.
- 5.3 Хэрэглэгчийн арилжаанд оролцсон хослолын төрлөөс хамааран ханшийн зөрүү үүсдэг ба тухайн зөрүү нь хослол бүрт харилцан адилгүй байдаг учир нарийвчлан тодорхойлох боломжгүй болно. (Жишээлбэл: USDEUR ханш авах захиалга: 0.9062, зарах захиалга: 0.9058 буюу 0.0004 зөрүүтэй байна.)
- 5.4 Энэхүү үйлчилгээний хураамж нь крипто хослолууд дээр арилжаанд оролцсон лотны хэмжээнээс хамааран 0.03% хүртэл байна. [/2025.08.08-ны нэмэлт, өөрчлөлт болно/](#)

ЗУРГАА.ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 6.1. Үйлчилгээ үзүүлэгч нь дараах үндэслэлээр гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:
- 6.1.1 Хэрэглэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;
 - 6.1.2 Хэрэглэгч нь арилжааны платформ болон үйлчилгээ үзүүлэгчийн системийн доголдлыг ашиглан үндэслэлгүй хөрөнгөжсөн;
 - 6.1.3 Энэхүү гэрээний хавсралт “Үйлчилгээний нөхцөл”-ийн 4.2.3-т заасан шаардлагыг хангаагүй нь тогтоогдсон;
 - 6.1.4 Хэрэглэгчийн арилжааны түүхийг хянан, шалгахад хязгаарлалтын арга хэмжээ авах шаардлагатай байх тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч өөрийн шийдвэрээр гэрээг цуцлах эрхтэй.
- 6.2. Хэрэглэгч нь дараах тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчид хүсэлт гаргаж, гэрээ цуцлах эрхтэй болно. Үүнд:
- 6.2.1 Үйлчилгээ үзүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;
 - 6.2.2 Өөрийн хүсэлтээр гэрээг цуцлах эрхтэй болно.

ДОЛОО.БАТАЛГАА

- 7.1 Хэрэглэгч нь энэхүү гэрээ болон “Үйлчилгээний нөхцөл”-ийг бүрэн хүлээн зөвшөөрч дараах батлагааг гаргаж байна. Үүнд:
- 7.1.1 Хэрэглэгч миний бие үйлчилгээ үзүүлэгчээс анхааруулж буй эрсдэл, сэрэмжүүлэг, хөшүүрэг ашигласан форекс арилжааны онцлог, түүний эрсдэлийн мэдээллийг бүрэн авч өөрийн арилжааны дансны тодорхой хэсгийг болон бүхэлд нь алдаж болзошгүй гэдгийг ойлгож, хүлээн зөвшөөрснөөр арилжаанд оролцох болно.
 - 7.1.2 Хэрэглэгч миний бие олон улсын болон дотоодын эдийн засгийн гэмт хэрэгт холбогдож, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрчиж, аливаа эдийн засгийн хориг, хязгаарлалтанд орж байгаагүй болно.

- 7.1.3 Хэрэглэгч миний бие арилжаанаас олсон ашгаасаа хувь хүний орлогын албан татвар, үйлчилгээний хураамж, бусад татваруудыг төлөх болно.
- 7.1.4 Хэрэглэгч миний бие арилжааг урвуулан ашиглах системийн алдаа болон үйлчилгээний нөхцөл, энэхүү гэрээгээр зохицуулаагүй тулгамдаж буй асуудлыг үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэж, засварлуулах болно. Хэрэв үүнийг ашиглан үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн тохиолдолд төлж барагдуулна.
- 7.1.5 Хэрэглэгч миний бие энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, өөрийн бүртгэл болон арилжааны дансны мэдээллийн аюулгүй байдлыг хангах болно.

НАЙМ.АЛБАН ЁСНЫ МЭДЭГДЭЛ

- 8.1 Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйл ажиллагаа болон энэхүү гэрээ, “Үйлчилгээний нөхцөл”-тэй холбоотой албан ёсны мэдэгдлийг дараах сувгуудаар дамжуулан мэдэгдэнэ. Үүнд:
 - 8.1.1 Facebook хуудас - <https://www.facebook.com/motfxofficial> ;
 - 8.1.2 Telegram групп - <https://t.me/+blQ9UVTHbFE3MWM1> ;
 - 8.1.3 Веб сайт - <https://www.motforex.com> ;
 - 8.1.4 Instagram- <https://www.instagram.com/motfxofficial/>.
- 8.2 Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой дараах төрлийн албан ёсны мэдэгдлийг гаргана. Үүнд:
 - 8.2.1 Гэрээ болон үйлчилгээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулахад;
 - 8.2.2 Үйлчилгээтэй холбоотой хөнгөлөлт, урамшуулал, өөрчлөлтийг зарлахад;
 - 8.2.3 Техникийн шалтгааны улмаас түр зогсох, засвар үйлчилгээ хийгдэхэд;
- 8.3 Энэхүү албан ёсны мэдэгдлийг гэрээний 8.1-т заасан мэдээллийн сувгаар мэдэгдсэн үеэс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба ажлын 1 хоногийн дотор хэрэглэгчээс аливаа санал, гомдол, хүсэлт ирүүлээгүй бол хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- 8.4 Үйлчилгээ үзүүлэгчээс энэхүү гэрээний 8 дугаар зүйлийн 8.1-т зааснаас бусад сувгаар мэдээлэл хүргэхгүй бөгөөд хэрэглэгч та албан ёсны мэдээллийн сувгуудаас мэдээлэл авч, өөрийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

ЕС.ХАРИУЦЛАГА

- 9.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчснөөс учирсан хохирлыг буруутай тал нь бүрэн хариуцана.
- 9.2 Үйлчилгээ үзүүлэгч нь дараах эрсдэлийг хариуцахгүй болно. Үүнд:
 - 9.2.1 Үйлчилгээ үзүүлэгч нь олон улсын зах зээлийн мэдээ, мэдээлэл, аливаа зах зээлийн хязгаарлалт болон энэхүү гэрээний 10 дугаар зүйлд заасан давагдашгүй хүчин зүйлийг;
 - 9.2.2 Үйлчилгээ үзүүлэгчийн систем нь цахим халдлагад өртөх эсхүл ирээдүйд учирч болзошгүй, үйлчилгээ үзүүлэгчийн хянах боломжгүй бусад бүх эрсдэлийг;
 - 9.2.3 Олон улсын хэм хэмжээ, мэдээ мэдээлэл, хууль тогтоомжоос арилжааны хослол, индексийн үнэ огцом өөрчлөгдөх эрсдэлийг;
 - 9.2.4 Хэрэглэгч өөрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаагүйгээс үүдэн гуравдагч этгээд зөвшөөрөлгүйгээр хэрэглэгчийн дансыг ашиглах эсхүл залруулах боломжгүй, залилан мэхлэх шинжтэй гүйлгээ, цахим халдлагыг;
 - 9.2.5 Хэрэглэгч энэхүү гэрээ болон үйлчилгээний нөхцөл заасан үүргээ зөрчсөн тохиолдолд түүнээс үүссэн аливаа хохирлыг;
 - 9.2.6 Хэрэглэгч арилжааны хөдөлгөөнийг буруу таамагласан, арилжааны БОТ ашигласан, үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээг буруу ойлгосон, үйлчилгээний нөхцөл болон гэрээг ойлгоогүй зэрэг бусад хэрэглэгчийн үйлдэлтэй холбоотой эрсдэлийг хариуцахгүй болно.

АРАВ.ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 10.1 Гэнэтийн давагдашгүй нөхцөл байдлын улмаас буюу үер, газар хөдлөлт, цаг агаарын онцгой нөхцөл байдал, байгалийн гэнэтийн хүчин зүйлс, гал түймэр, дайн, бослого, үймээн самуун, халдварт өвчин, аливаа бүх төрлийн осол, засгийн газрын үйл ажиллагаа, шийдвэр,

хориг, харилцаа холбоо болон цахилгаан тасрах, тоног төхөөрөмж болон программ хангамж эвдрэх, хакер халдлага зэрэг үйлчилгээ үзүүлэгч хянах боломжгүй нөхцөлд <https://www.motforex.com>-ийн үйл ажиллагаа тасалдах, түр зогсох, засвар үйлчилгээ хийх тохиолдолд үйл ажиллагааг хэвийн горимд шилжих хүртэлх хугацаанд учирсан хохирлыг үйлчилгээ үзүүлэгч хариуцахгүй болно.

АРВАН НЭГ.БУСАД ЗҮЙЛ

- 11.1 Энэхүү гэрээтэй холбоотой талуудын хооронд үүсч болзошгүй бүх санал зөрөлдөөн, аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжоор шийдвэрлэнэ.
- 11.2 Энэхүү гэрээ болон үйлчилгээний нөхцөлөөр зохицуулаагүй аливаа харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 11.3 Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний өөрт үлдэх хувийг цахим хэлбэрээр хадгалах ба хэрэглэгчийн цахим гарын үсгээр баталгаажуулна.
- 11.4 Энэхүү гэрээний хавсралт нь гэрээний адил хүчин төгөлдөр байна.

ooOoo

